САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

2019.05.01

*ТА **ИНТЕРНЕТ БАНК** БОЛОН **319708, 319709** УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.*

Валют	Ханш	24H Chg
EUR/USD	1.1186	0.00%
USD/CNY	6.7436	0.02%
USD/RUB	64.467	0.02%
USD/JPY	111.54	-0.10%
USD/KRW	1163.95	0.47%
USD/CHF	1.0193	-0.51%
AUD/USD	0.7043	0.04%
GBP/USD	1.2939	0.00%
Индекс	**Нэгж**	**24H Chg**
Dow Jones	26554.4	0.04%
S&P 500	2943.0	0.11%
NASDAQ	8161.9	0.19%
FTSE 100	7440.7	0.17%
Nikkei 225	22258.7	-0.22%
DAX	12328.0	0.10%
Hang Seng	29748.8	-0.48%
SHCOMP	3075.7	0.43%
Метал	**Ханш (USD)**	**24H Chg**
Алт	1283.52	0.28%
Мөнгө	14.964	0.31%
Нүүрс (Чин хуанг дао/юань)	616	0.00%
Хүрэн нүүрс (БНХАУ)	39.35	3.63%
Зэс (LME)	6396	-0.06%
Төмрийн хүдэр	637	1.76%
Газрын тос (NYME)	63.41	-0.14%
Бонд	**Хүү**	**24H Chg**
US 1M LIBOR	2.48%	0.00%
US 3M LIBOR	2.58%	-1.37%
US 6M LIBOR	2.61%	0.00%
US 12M LIBOR	2.71%	0.05%
US Treasury 10Y	2.53%	1.08%
UK Treasury 10Y	1.16%	1.31%
GE Treasury 10Y	0.00%	113.64%
JP Treasury 10Y	-0.04%	0.00%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24H Chg
Гэрэгэ	5.63%	5/1/2023	5.96%	-0.02%
Мазаалай	10.8%	4/6/2021	5.10%	-0.11%
Хуралдай	8.75%	3/9/2024	6.15%	-0.05%
Чингис	5.13%	12/05/2022	5.62%	0.03%
ХХБ 2020	9.38%	5/19/2020	5.97%	-0.01%
Самурай	5.75%	12/25/2023	0.62%	0.01%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	6.64%	-0.18%
МИК 2022	9.75%	1/29/2022	9.09%	-0.05%

Онцлох мэдээ

- Д.Трамд Холбооны Нөөцийн банканд бодлогын хүүг бууруулах дарамт өгсөөр байна. Мөн бонд худалдан авалтыг сэргээхийг шаарджээ.
- АНУ ирэх 2 долоо хоногийн хугацаанд худалдааны гэрээг БНХАУ-той тохиролцож чадахгүй бол дараагийн арга хэмжээг авна гэдгээ мэдэгдлээ.

Валютын зах зээл

Еврогийн ханш ам.долларын эсрэг нэг долоо хоногийн дээд цэгээ тогтоолоо. Евро бүсийн эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны хоёрдугаар хагаст уналттай байсан хэдий ч энэ оны эхний улиралд 0.4%-н өсөлтийг харуулсан нь таамгаас давсан дүн байлаа. Улмаар еврогийн ханш 0.3%-р чангарч 1.1219 нэгжид хүрсэн байна.

Ам.долларын ханш харьцангуй тогтвортой арилжигдаж байгаа бөгөөд үүнд нөлөөлөх тус улсын ажил эрхлэлтийн мэдээ хүлээгдэж байна. Мөн Холбооны Нөөцийн банкны ээлжит бодлогын уулзалт өнөөдрөөс эхлэсэн ба бодлогын хүүнд өөрлөлт орох хүлээлт байхгүй хэдий ч инфляцийн сул үзүүлэлт болон эдийн засгийн өсөлтийн талаар Ж.Пауэл ямар байр суурь илэрхийлэхийг шинжээчид хүлээж байна.

Их Британийн зарим хэвлэлүүдээр BREXIT-н хэлэлцээрийн асуудлууд урагштай явж байгаа талаар гарсны дараа фунтын ханш 2 долоо хоногийн дээд ханшийг тогтоож 1.30 нэгжийг дээш сэтэлсэн байна. Times сонинд мэдээлснээр Т.Мэйн засгийн газар сөрөг хүчнийхэнтэй уулзаж том алхам хийж байгаа талаар мэдэгдсний дараа фунтын ханш 1.3049-д хүржээ.

Алтны зах зээл

Лондонгийн металлын бирж дээр алтны ханш нэг унц нь 1,282.30 ам.долларт хаагдсан байна. Хөрөнгө оруулагчид Холбооны нөөцийн банкны хурлыг хүлээсэн байдалтай байгаа энэ үед ам.доллар бусад валютын эсрэг суларч эхэлсэн нь алт бага зэрэг өсөх шалтгаан боллоо. Шинжээчид цаашид алтны ханш томоохон өөрчлөлтийг харуулалгүй тогтвортой байх талаар ярьж эхэллээ.

Зэсийн зах зээл

БНХАУ болон АНУ-ын худалдааны хэлэлцээр албан ёсоор Бээжинд хуралдаж эхэллээ. Энэхүү хэлэлцээрээр тус 2 улсын удаан хугацаанд өрнөөд буй худалдааны маргаан эцэс болох төлөвтэй байгаа бөгөөд голлох металлуудын ханш Лхагва гаригийн байдлаар өслөө. Лондонгийн металлын бирж дээр 1 тонн зэсийн ханш 0.3 хувиар өсөн 6,434.50 ам.долларт арилжаалагдаж байна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

Хувьцаа	Ханш	24H Chg
Turquoise Hill Resources	1.51	1.34%
Mongolian Mining Corp	0.144	-1.37%
Mongolian Energy Corp	0.20	0.00%
Centerra Gold	6.78	-0.44%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2019 (II)	6.9%
Бодлогын хүү	2019 (III)	11.0%
Банк хооронын зах зээлийн хүү	2019 (II)	11.0%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2019 (II)	12.0%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2019 (II)	5.3%
Зээлийн дундаж хүү (төг)	2019 (II)	17.0%
Зээлийн дундаж хүү (валют)	2018 (II)	10.7%

Ханшийн таамаглал

Валют	Q3 19	Q4 19	Q1 20	Q4 20	2021
EUR/USD	1.15	1.16	1.18	1.22	1.24
GBP/USD	1.34	1.36	1.38	1.43	1.45
USD/CNY	6.75	6.78	6.78	6.8	6.7
USD/JPY	110	109	108	104	102
USD/RUB	66	67	66.5	65	64.4
Түүхий эд					
Алт	1325	1345	1365	1367	1325
Зэс	6400	6500	6418	6800	6900
Нүүрс	73	72	72	71	72

эх сурвалж: Блүмбэрг

Эдийн засгийн голлох тоо мэдээ

Өмнөх өдрийн үр дүн	Таам.	Үр дүн	Өмнөх
US GDP Annualized QoQ	2.3%	3.2%	2.2%
US Personal Consumption	1.0%	1.2%	2.5%
US GDP Price Index	1.2%	0.9%	1.7%
Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
US Personal Income	20:30	0.4%	0.2%
US Personal Spending	20:30	0.7%	-
Маргааш хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
FR GDP QoQ	13:30	0.3%	0.3%
FR GDP YoY	13:30	1.1%	1.0%
EC GDP SA QoQ	17:00	0.3%	0.2%
EC GDP SA YoY	17:00	1.1%	1.1%
GE CPI MoM	17:00	0.5%	0.4%
GE CPI YoY	17:00	1.5%	1.3%

Газрын тосны зах зээл

АНУ-ын газрын тосон бүтээгдэхүүний нөөцийн хэмжээ нэмэгдсэнээр газрын тосны ханш буурсан боловч Венесуэл улсад өрнөөд буй улс төрийн үймээн болон Иран улсын эсрэг хэрэгжүүлж буй худалдааны хориг арга хэмжээ нь зах зээлд оролцогчдын анхаарлын төвд байсаар байна. WTI фьючерсын үнэ 0.8 хувь бууран 63.49 ам.долларт хаагдсан бол Брент газрын тосны ханш 0.6 хувиар буурч 71.65 ам.долларт арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

“JPMorgan Chase&Co” компани 11 жилийн хугацаатай 2.5 тэрбум ам.долларын бонд олон улсад арилжаалахаар болсон байна. Мөн Өмнөд Солонгосын “Mirae Asset Daewoo” компанийн 5 жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондод нийт 2.25 тэрбумын захиалга бүртгэгдсэн байна. Нийт захиалгын дийлэнх буюу 70 хувийг хөрөнгө оруулалтын сангууд, 24 хувийг банкууд эзэлжээ.

Хөрөнгийн зах зээл

АНУ-ын хөрөнгийн зах зээл дээр голлох индексүүд “Dow Jones” 0.2%, “S%P 500” 0.1% өссөн бол “Nasdaq” 0.7% буурсан байна. Хөрөнгө оруулагчид Холбооны нөөцийн банкны хурлыг хүлээж байгаа нь зах зээлд дарамт болж байгааг шинжээчил онцолсон ба эдийн засгийн өсөлт, худалдааны маргааны асуудал наашгай шийдэгдэж байгаа нь цаашид өсөх шалтгаан болно гэж үзлээ. Эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаа голлох өсөлтийг харууллаа.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мейлд хариу илгээнэ үү.